# НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 30 өдөр Дугаар А/57 Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан долоон аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.
2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан гурван иргэн, аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.
3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан гурван иргэн, аж ахуйн нэгжийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.
4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.
5. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн С.Туулд үүрэг болгосугай.
6. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.

ДАРГА Э.БАТТУЛГА

YOA0453

1150500181

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 20.15. оны 06/30 сарын 1/.. өдрийн .... тоот тушаалын нэгдүгээр хавсралт

УОА0453

# ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

2015.06.29 Улаанбаатар хот

| *Д/д* | *Иргэн, аж ахуйн нэгжийн нэр* | *Оноосон нэр* | *Байршил* |
|---|---|---|---|
| 1 | Дун Өргөө ХХК | Өргөө | Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жуулчны гудамж м/100 |
| 2 | Уран Дриллинг ХХК | Уран мотел | Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 49/1 |
| 3 | Уран Дриллинг ХХК | Дисковери | Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 49 ж |
| 4 | Сод трейд ХХК | Сод | Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 46/12 |
| 5 | Зүүн баян рефайнери ХХК | Пийс бридж | Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Дунд голын 47 |
| 6 | Элкс трейд ХХК | Элкс | Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө |
| 7 | Ти энд Жи ХХК | Нью Вест | Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө |

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 20.15 оны 06. сарын 30 өдрийн А/57 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

УОА0453

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ

2015.06.29 Улаанбаатар хот

| *Д/д* | *Иргэн, аж ахуйн нэгжийн нэр* | *Оноосон нэр* | *Байршил* |
|---|---|---|---|
| 1 | Иргэн М.Мөнх-Эрдэнэ | Секрет | Баянгол дүүрэг, 16-р хороо, Туулын 18/360 |
| 2 | Глади ХХК | Глади | Баянгол дүүрэг, 9-р хороо, Горькийн 1/23 |
| 3 | Жэй Ай Өү ХХК | Сайхан хангай | Сонгинохайрхан дүүрэг, 27-р хороо, Агарын 27/15 |

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2015 оны 06 сарын 30 өдрийн А/57 тоот тушаалын гуравдугаар хавсралт

YOA0453

# ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

2015.06.29 Улаанбаатар хот

| *Д/д* | *Иргэн, аж ахуйн нэгжийн нэр* | *Оноосон нэр* | *Байршил* |
|---|---|---|---|
| 1 | Иргэн Ц.Чинзориг | Хан Хөхий | Баянзүрх дүүрэг, 27-р хороо, Дунд Дарь эхийн гудамж 5 |
| 2 | Нью Энкис ХХК | Тулга | Баянгол дүүрэг, 3-р хороо, Замчдын гудамж |
| 3 | Есөн гарьд ХХК | Онон | Баянзүрх дүүрэг, 5-р хороо, Өлгийн 31/408 |

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 20.16 оны 06 сарын 30 өдрийн А/57 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

YOA0453

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

2015.06.29 Улаанбаатар хот

| *Д/д* | *Иргэн, аж ахуйн нэгжийн нэр* | *Оноосон нэр* | *Байршил* |
|---|---|---|---|
| 1 | Батхаан Групп ХХК | Батхаан | Сонгинохайрхан дүүрэг, 24-р хороо, Толгойтын баруун салаа, Баянбумбатын ам |

-ооОоо-